

МБСХ-НЫ ШҮҮГЧДИЙН ЗАН БАЙДАЛ, ЁС СУРТАХУУНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ

ДҮРЭМ

1. Урьдчилсан журам

Спортын бүжгийг олимпийн төрлийн спортоор хүлээн зөвшөөрүүлэхээр чармайж буй бидний зорилго урагш ахихын хирээр Олон Улсын Бүжгийн Спортын Холбоо ба Монголын Бүжгийн Спортын Холбооны нэр хүндийг хамгаалан бэхжүүлэх асуудал эрхэм чухал зүйл болж байна. Бидний үйл ажиллагаа хууль ёсны бөгөөд гоо зүйд нийцсэн байхын тулд энэхүү нэр хүндийг хадгалах нь бидний зан байдал Олимпийн Хартад тодорхойлсон зарчим ба үнэт зүйлсийг бүрэн тусгасан байхыг шаардаж байна.

“МБСХ-ны шүүгчдийн Дүрэм ба зан байдлын гоо зүйн хэм хэмжээ” гэж нэрлэгдсэн энэхүү баримт бичгийн зорилго нь (цаашид “Дүрэм” гэнэ) шүүгчдийн ёс суртахуун ба зан байдлын стандартыг тогтоох үндэс суурийг бий болгох явдал юм. Түүнийг МБСХ-ны Тэргүүлэгчдээс шүүгчид өөрсдийн мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулах үедээ үнэнч, нэр хүндтэй, үр ашигтай байх хариуцлагын үндсэн зарчмыг тодорхойлсон ОУБСХ-ны ижил төстэй дүрмийг үндэслэн боловсруулав.

Энэхүү хэм хэмжээний дүрэм нь шүүлтийн объект болсон бусад шүүгчид, тамирчдын зүгээс, ОУБСХ-ны зүгээс, МБСХ, түүний гишүүдийн зүгээс, БТСУХ, МҮОХ/ОУОХ зэрэг спортын удирдах байгууллагууд, өргөн олны зүгээс шүүгчдэд итгэх итгэлцлийг бэхжүүлэхэд тус нэмэр болох зан байдлын стандартыг хэлбэршүүлэхэд дөхөм үзүүлэх зорилготой.

МБСХ энэхүү Дүрэм нь шүүгчид өөрсдийн үүргээ гүйцэтгэх явцад тулгарч болох боломжит бүх нөхцлийг тусгах боломжгүй гэж үзэж байна. Энэ тохиолдолд тухайн шүүгч өөрийн гоо зүй ба мэргэжлийн зан байдал, дотоод сэтгэлээрээ шүүлтийг хөтлөн явуулах хэрэгтэй.

Дүрэмд заагдсан стандартуудыг мөрдөх явдал нь МБСХ-ны алс хэтдээ оршин тогтнох чухал зүйл учраас бүх шүүгчид энэхүү стратегийн баримт бичгийн агуулгатай танилцах шаардлагатай.

МБСХ бүх шүүгчид энэхүү Дүрэмд заагдсан заалтууд болон ОУБСХ, ОУОХ, МБСХ-ны үнэт зүйлс, зарчмуудад нийцсэн зан байдлыг дагаж мөрдөх талаар хувийн хариуцлага хүлээнэ гэж үзнэ.

Энэхүү Дүрэм нь МБСХ-ны бүх зэрэглэлийн шүүгчдэд үйлчилнэ.

МБСХ-ны Тэргүүлэгчид энэхүү Дүрэмд хэзээ ч аливаа өөрчлөлтийг оруулах эрхтэй.

2. Сонирхлын зөрөлдөөн

Сонирхлын зөрөлдөөн гэдэгт тамирчдын үзүүлбэрийг урьдаас таамаглахгүйгээр, гуравдагч этгээдийн сонирхлыг тооцохгүйгээр, зөвхөн тэдний ур чадварыг удирдлага болгон дүгнэх шүүгчдийн үүрэгтэй нийцэхгүй аливаа ил ба далд сонирхол, харьцаа, холбоо эсвэл үйл ажиллагааг ойлгоно.

Бусад этгээдийн сонирхлууд шүүгчдийн чадварт ил далдаар нөлөөлснөөс болж сонирхлын зөрөлдөөн үүснэ.

Шүүгчид нь энэхүү Дүрэмд заагдсан эрх ашгийн будлианыг арилгахтай холбоотой заалтуудыг биелүүлэх, харин сонирхлын эрх ашгийн ил, далд зөрөлдөөн үүсэн гарсан тохиолдолд сайн дураар шүүгчдийн коллегийн бүрэлдэхүүнээс гарах ёстой.

3. Шүүгчдийн дүрэм

3.1. Хэрвээ шүүгч бие болоод сэтгэл санааны байдлаас шалтгаалж шүүгчийн үүргээ бүрэн хэмжээгээр гүйцэтгэх боломжгүй нь тодорхой бол шүүлтийг явуулахыг хориглоно.

3.2. Хэрвээ тамирчдын хэн нэг нь шүүгчийн ойрын эсвэл холын хамаатан бол, мөн түүнтэй хуулиар тогтоогоогүй боловч de facto байх харьцаатай бол, мөн өрсөлдөж байгаа тамирчдын хэн нэгтэй шүүгчийн албан үүргээ явуулахад боломжгүй болохоор бусад харьцаатай бол шүүлтийг явуулахыг хориглох бөгөөд өөрийн санаачилгаар тэмцээний шүүгчдийн коллегийн бүрэлдэхүүнээс гарах ёстой.

3.3. Тухайн шүүгчдийн хэсгийн шүүгчдийн хэн нэг нь түүний ойрын эсвэл холын хамаатан бол, мөн түүнтэй хуулиар тогтоогоогүй боловч de facto байх харьцаатай бол, мөн шүүгчдийн хэн нэгтэй шүүгчийн албан үүргээ явуулахад боломжгүй болохоор бусад харьцаатай бол шүүлтийг явуулахыг хориглох бөгөөд өөрийн санаачилгаар тэмцээний шүүгчдийн коллегийн бүрэлдэхүүнээс гарах ёстой.

“Ойрын эсвэл холын хамаатан” гэдэг ойлголтонд шүүгчтэй цусан төрлийн (хоёр дахь үеийн хамаатан хүртэл) эсвэл ах дүүгийн, үрчилж авсан харьцаа, мөн хамтын амьдралын (хамтран амьдрах) харилцааг ойлгож болно.

3.4. Шүүгч нь тамирчид, тэдний хамаатан, тэмцээний зохион байгуулагчид зэрэг түүний шийдвэрийг өөрчлөх сонирхолтой гуравдагч этгээдээс мөнгө, шагнал, материаллаг үнэ цэнтэй эд зүйлс, хожим шагнахаар амласан амлалт, үйлчилгээний хөлс хэлбэрийн бэлгийн зүйлс авахыг хориглоно.

3.5. Шүүгч өөрийн нэр хүнд болон мэргэжлийн туршлагын талаар эндүү ташаа мэдэгдэл хийхийг хориглоно.

3.6. Шүүгч өөрийн шүүгчийн зэрэглэлтэй холбоотой асуудлаар эндүү ташаа мэдэгдэл хийхийг хориглоно.

3.7. Шүүгч хувьдаа болон гуравдагч этгээдэд ашиг хонжоо гаргаж авах зорилгоор хэн нэгэнд тухайн болон бусад хосуудад ямар нэг үнэлгээ тавихыг ятгаж сэнхрүүлэх, сүрдүүлэх эсвэл тэмцээний төгсгөлд нөлөөлөх зорилгоор тамирчныг аливаа үйл үйлдэх эсвэл үйлдэхгүй байхыг албадан тулгахыг хориглоно.

3.8. Шүүлт явуулж байгаа тэмцээнийхээ явцад шүүгч тэмцээний төгсгөлд нөлөөлөх зорилгоор тэмцээнд оролцож байгаа аль нэг хосыг занах, дохио зангаа хэлбэрээр (жишээлбэл, нүүрний хувирал) болон аман хэлбэрээр дарамтлахыг хориглоно.

3.9. Шүүлт явуулж байгаа тэмцээн дээрээ шүүгч тэмцээнд оролцож байгаа хосуудад дасгалжуулалтын ба сурганы үйл ажиллагаа явуулах, тэдэнд зөвөлгөө өгөх г.м-ийг хориглоно.

3.10. Шүүгч тэмцээний явцад дүгнэж байгаа аль нэг хосын хөгжөөн дэмжигчдийн нөлөөнд автагдах ёсгүй.

3.11. Шүүгч бусад шүүгчдэд нөлөө үзүүлэх, тэднийг дарамтлахыг хориглоно.

3.12. Тухайн тэмцээний шүүгчдийн коллегийн бүрэлдэхүүнд багтаагүй шүүгч сүүлийн давааны төгсгөл хүртэл энэхүү тэмцээний шүүгчээр ажиллаж байгаа шүүгчтэй аль тамирчны талаар шүүн хэлэлцэхийг хориглоно.

3.13. Шүүлт явуулж байгаа шүүгч сүүлийн давааны төгсгөл хүртэл тэмцээнд оролцож байгаа хэн нэг тамирчинтай ярилцахыг хориглоно.

3.14. Шүүгч тэмцээнд оролцож байгаа бүх хосуудад тэдний үзүүлбэрийн чанар ба тэдний ур чадварын түвшинг үнэн зөв харуулсан үнэлгээ өгөхөөс бусад өөр аргаар тэмцээний төгсгөлд нөлөө үзүүлэхийг хориглоно.

3.15. Шүүгч аливаа хосд түүний үзүүлбэрийн чанар ба түүний ур чадварын түвшинг үнэн зөв харуулахаас өөрөөр үнэлгээ тавихыг хориглоно.

3.16. Шүүгч тэмцээнд оролцож байгаа хэн нэгнийг нөгөөгийн өмнө оруулахад чиглэсэн аливаа үйлдэлд оролцохыг хориглоно.

3.17. Шүүгч өөрийгөө МБСХ-ны төлөөлөгч эсвэл албаны хүн болох тухай эндүү ташаа мэдэгдэл хийхийг хориглоно.

- 3.18. Тэмцээний явцад бусад шүүгчид, үзэгчид, тамирчид, тэдний дасгалжуулагчидтай харилцах үедээ шүүгч тухайн тэмцээний сүүлчийн давааны дуустал шүүж байгаа хосуудын үзүүлбэрийн талаар ярилцахыг хориглоно.
- 3.19. Шүүгч тэмцээн эхлэхийн өмнөөс шагнал гардуулах ёслол хүртэл согтууруулах ундаа эсвэл мансууруулах бодис хэрэглэхийг хориглоно.
- 3.20. Шүүгч хойшлуулшгүй шалтгаанаас (өвчин, нисэх онгоц/галт тэрэгний буудал руу явах) бусад тохиолдолд финалистуудыг шагнал ёслол дээр байлцах ёстой.
- 3.21. Шүүгч МБСХ-ны болон бүжгийн спортын нэр хүндийг муутгах аливаа үйлдэл гаргахгүй байх ёстой.

4. Шүүгчдийн ерөнхий зан байдал

Шүүгч маш итгэлтэй байдлыг эзэмшсэн байх үүрэгтэй. Шүүгчид шүүлт явуулж байгаа тэмцээнийхээ эхэн, дундуур, төгсгөлд ч тэмцээний бусад субъектуудад тавигдсанаас илүү өндөр зан байдлын стандартад зохицсон байх ёстой.

4.1 Шүүгч зан байдлын өндөр хэм хэмжээтэй байхын тулд дараах дүрмийг баримтлах ёстой:

4.1.1. Тэмцээний талбай дотор шүүгчдийн зан байдал спортын шударга байдлын зарчимд нийцэх ёстой. Шүүгч олны өмнө (тамирчид, үзэгчид ба спортын байгууллагын төлөөлөгчд) эсвэл бүжгийн спорттой холбоотой бусад ажил үүрэг гүйцэтгэж байх үедээ биеэ итгэлгүй эсвэл үзэмжгүй авч явахыг хориглоно.

4.1.2. Шүүгч өөрийн шийдвэртээ тууштай, бодит, шударга байх ёстой. Урьдаас таамагласан шүүлт нь тэмцээний болон бүх спортын үндэс суурийг гутаана.

4.1.3. Шүүгч өөрийн шүүгчдийн коллегийн үнэнч шударга байдалд эргэлзэж буйгаа олон нийтийн өмнө илэрхийлэхийг хориглоно.

4.1.4. Шүүгчийн үүргээ гүйцэтгэх үедээ урьд нь өөрийн бэлдэж байсан тамирчдын дүнг бууруулж байсан гэсэн үндэслэлээр урьд өөр тэмцээн дээр шүүгчийн үүрэг гүйцэтгэж байсан мэргэжилтний дасгалжуулж байгаа хосын үнэлгээг бууруулах эсвэл үнэлгээг бууруулахаар сүрдүүлэхийг хориглоно.

4.1.5. Өөрийн дасгалжуулсан хосуудыг шүүх тохиолдолд шүүгч энэхүү Дүрэмд зохицуулан шударга урьдчилан таамаглаагүй ажиглагчийн байр сууринаас үүргээ гүйцэтгэх үүрэгтэй.

4.1.6. Урьд нь өөрийн дасгалжуулж байсан хосыг шүүх үедээ шүүгч одоо дасгалжуулж байгаа дасгалжуулагчийг өөрийн дасгалжуулж байсантай харьцуулах замаар шүүлтийг явуулахыг хориглоно.

4.1.7. Шүүгч хүн өөрийн мэдлэг чадвараа хөгжүүлж, бүжгийн гүйцэтгэлийн техник ба стилийн хөгжлийн сүүлийн үеийн түвшний тухай, мөн ОУБСХ ба МБСХ-ны тогтоосон шүүлтийн зарчмууд тухай мэдээллийг олж авч байх үүрэгтэй.

4.1.8. ОУБСХ ба МБСХ-ны шүүлтийн шалгуурт зохицсон өөрийн мэдлэг, туршлага ба дадлаа ашиглан шүүгч бусдын гүйцэтгэж байгаа бүжгийн хэв маяг дээр ягштал тогтсон тогтсон үзэл бодлоо гаргахыг хориглоно.

4.2 Зохих зэрэглэлийг зэмших ба хадгалах үндсэн нөхцөл нь шүүгчид дараах үүргийг биелүүлэх явдал юм:

4.2.1. Тэмцээн явагдах газарт цагтаа ирэх ба бие болоод сэтгэл санааны хангалттай байдалтай байх;

4.2.2. Өөрийн ирсэн тухайгаа тэмцээний зохион байгуулагч ба ерөнхий шүүгчид илтгэх;

4.2.3. Тэмцээний хуваарийг нарийвчлах;

4.2.4. Тэмцээний тогтоосон хуваарьт зохицуулан шүүгчийн үүргээ биелүүлэхэд бэлэн байх;

- 4.2.5. Тэмцээний явцад өөрийн зан байдлаар бүжгийн спорт ба МБСХ-ны нэр алдрыг өндөрт өргөх;
- 4.2.6. Тамирчид ба коллегитой харилцаанд орохгүйн тулд бие биеэсээ зайтай (2-3 метр) зогсох буюу сууна.
- 4.2.7. Завсарлагааны танхим, тэмцээний зааланд, талбайн ойролцоо шүүлт явуулах үедээ бие биетэйгээ харилцахаас эрс татгалзах;
- 4.2.8. Өрсөлдөж байгаа бүх хосуудыг харж болохуйц дурын байрлалд шилжих;
- 4.2.9. Шүүлтийг бусдаас хамааралгүй сайтар явуулах, шүүлтийн хуудас дээрх өөрийн үнэлгээг бусад шүүгчдийн үнэлгээтэй харьцуулахгүй байх;
- 4.2.10. Хуудас дээр гарын үсгээ зурж, хувийн кодоо нөхөж бичих, шүүлтийн хуудас дээрх бүх өөрчлөлт засварыг өөрийн гарын үсгээр баталгаажуулах;
- 4.2.11. Даваа бүрийн дараах завсрын үр дүн болон тэмцээнийг дуусах хүртэл тэмцээн шүүж байгаа бусад шүүгчдийн үнэлгээтэй танилцах оролдлого хийхгүй байх;

5. Тэмцээний үед шүүгчдийн үйлдэлд гаргасан гомдол

Тэмцээний явцад ерөнхий шүүгч нь тухайн тэмцээнд оролцож байгаа болон оролцоогүй шүүгчдийн энэхүү Дүрмийг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих эрх, үүрэгтэй.

Зөвхөн МБСХ-ны албаны төлөөлөгч тэмцээний явцад шүүгчдийн үйлдэл эсвэл зан байдалд гаргасан гомдлын талаар ерөнхий шүүгчтэй харилцах эрх эдэлнэ.

Хэрвээ ерөнхий шүүгчийн бодлоор шүүгчдийн коллегийн хэн нэг нь энэхүү Дүрмийг зөрчсөн гэж үзвэл ерөнхий шүүгч тухайн шүүгчид түүний үйлдэлд гомдол гарсан тухай мэдээлэх, түүний тайлбарыг сонсох ба энэхүү Дүрэмд зохицсон арга хэмжээг нэн даруй авах эрх, үүрэгтэй.

Ерөнхий шүүгч шүүгчийг сануулах, анхааруулах, тэмцээнийг дуустал шүүлтээс тусгаарлах эрхтэй.

Ерөнхий шүүгч энэхүү Дүрмийг зөрчсөн шүүгчийн зан байдал эсвэл үйлдэлтэй холбоотой аливаа будлианыг тайлан хэлбэрээр бичиж баталгаажуулах үүрэгтэй. Тайланд энэхүү Дүрмийг зөрчсөн тухай таамаг, сэжигтэй холбоотой өөрийн ажиглалтыг илтгэн бичиж, сануулга, анхааруулга, шүүлтээс тусгаарласан баримтыг тэмдэглэнэ.

Ерөнхий шүүгч тухайн тайланг тэмцээн дууссанаас хойш гурван өдрийн дотор МБСХ-ны Тэргүүлэгчдэд гаргаж өгөх үүрэгтэй. МБСХ-ны Тэргүүлэгчид ойрын хурал дээрээ тэрхүү тайланг үзэж танилцан ерөнхий шүүгч ба энэхүү Дүрмийг зөрчсөн шүүгчийн үйлдэлд үнэлгээ өгч, цаашид шүүн байцаах ба/эсвэл нэмэлт шийтгэл өгөх тухай шийдвэр гаргана.

6. Тэмцээний дараа шүүгчдийн үйлдэл эсвэл зан байдалд гаргасан гомдол

Энэхүү Дүрмийг зөрчсөн тухай гомдлыг орон нутгийн байгууллагын удирдлагаас бичгээр тэмцээний дараа өгч болно.

Гомдлыг хянан шийдвэрлэхээр хүлээн авахын тулд дараах шалгуурыг хангах ёстой:

6.1. Гомдол нь бичгээр, МБСХ-ны гишүүн байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсэгтэй, зөрчил гарсан өдрөөс мөчөөс хойш арван өдрийн хугацаанд энэхүү зөрчлийг баталсан баримтын хамт МБСХ-ны Тэргүүлэгчдэд хүргэгдсэн;

6.2. МБСХ-ны гишүүн байгууллага гомдол гаргасан этгээдийн бүтэн нэр, хаяг, харилцах мэдээллийг заах ба МБСХ-ны Тэргүүлэгчдийн хуралд тайлбарыг хүргэхийн тулд гомдлын тухай мэдээлэх этгээдийг цуглуулах нөхцлийг хангах өөрийн зөвшөөрлөө илэрхийлнэ.

Хэрвээ өгөгдсөн гомдол гомдол өгөх тогтоосон шалгуурыг хангавал МБСХ-ны Тэргүүлэгчид хянаж шийдвэрлэнэ. Хэрвээ өгөгдсөн гомдол гомдол өгөх тогтоосон шалгуурыг хангахгүй бол МБСХ-ны Тэргүүлэгчид энэ тухай тухайн гомдлыг гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэх ёстой.

МБСХ-ны Тэргүүлэгчид аливаа гомдлыг хянан шийдвэрлэх эсвэл хянан шийдвэрлэхээс татгалзах эрхтэй. Тэргүүлэгчдийн шийдвэр эцсийнх байна.

7. Шүүгчдэд хэрэглэх сахилгын арга хэмжээ

Хэрвээ шүүгчид:

7.1. Дүрмийг илэрхий зөрчсөн;

7.2. Энэхүү Дүрмийн ямар нэг хэм хэмжээг санаатай зөрчсөн;

7.3. Тэргүүлэгчдийн үзсэнээр МБСХ-ны нэр хүнд ба/эсвэл ашиг сонирхолд хохирол учруулсан тохиолдолд МБСХ-ны Тэргүүлэгчид тухайн шүүгчийг зэмлэх эсвэл дараах сахилгын арга хэмжээнүүдийн аль нэгийг хэрэглэх эрхтэй:

- Аливаа түвшний тэмцээн шүүх эрхийг гурваас арванхоёр хүртэл сарын хугацаагаар хасна.
- Шүүгчийн зэрэглэлийг нэгээс хоёр хуанлийн жилийн хугацаагаар нэг түвшнээр бууруулна.
- Зэрэглэлийг нэг түвшнээр дээшлүүлэх хугацааг хоёроос гурван жилийн хугацаагаар хойшлуулна.
- МБСХ-ны шүүгчдийн коллегийн бүрэлдэхүүнээс нэн даруй хасна.

МБСХ-ны Тэргүүлэгчид тухайн шүүгчийн нэр дээр ирсэн гомдлын талаарх тайлбараа энэ талаар авч хэлэлцэхээр төлөвлөсөн МБСХ-ны Тэргүүлэгчдийн хурал болохоос өмнө бичгээр ирүүлэхийг түүнд бичгээр мэдээлэх ёстой.

МБСХ-ны Тэргүүлэгчид гомдлын талаар шүүгчээс тайлбар ирсэн ч ирээгүй ч номдлыг хянаж үзнэ. МБСХ-ны Тэргүүлэгчид гомдлын талаарх шийдвэрийг өөрсдийн үзэмжээр гаргана. Өргөдөл гаргагч ба шүүгчид бичгээр тайлбар өгсөн нөхцөлд шийдвэр нь эцсийнх болно.